



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (08)

2021.02.22

ТУУЛ ГОЛЫН ДАЛАН ДАВУУЛАН ҮНС ЗАЙЛУУЛСАН УСАА ХАЯЖ БАЙСНЫГ ТАСЛАН ЗОГСООЛОО



Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голд шугам хоолойгоор бохир ус хаясан асуудлаар Туул голын сав газрын захиргаа, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хамтран газар дээр нь ажиллаж, хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар “ДЦС-III” ТӨХК нь Туул голын далан давуулан үнс зайлуулсан усаа хаяж байсныг таслан зогсоож, малын сэг зэмийг халдваргүйжүүлж устгалын арга хэмжээг авч ажиллажээ. Мөн Туул голын далан давуулан хаяж буй үнс зайлуулсан ус болон хөрснөөс дээж авч, БОАЖЯ-ны харьяа Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид дээжүүдийг өгсөн байна. Шинжилгээний хариу гарсны дараа Усны тухай

хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу арга хэмжээг авч ажиллах юм байна. Асуудал үүссэн учир шалтгааныг "ДЦС-III" ТӨХК-ийн инженерүүдээс тодруулахад, зууханд үүссэн үнсийг шүүлтүүрээр шүүж, усаар тээвэрлэн үнсэн санд үнсийг хүргэж, саарал усыг тунгаан хуримтлуулж, станц руу шахаж дахин ашигладаг бөгөөд эдгээр шаталсан сангуудын ажиллагаа доголдоноос болж станцын үнсний шугамд бөглөрөл үүсч, үнсэн сангийн түвшин өндөр гарч, далан сэтэрх аюулд хүрснээс үүдэн аваарын шугам хоолойгоор тунгаагдсан үнс зайлуулсан усыг голд хаясан байна. "ДЦС-III" ТӨХК-ийн инженер техникийн ажилтнуудад дахин Туул голын далан давуулан үнс зайлуулсан ус хаяхгүй байх талаар нь шаардлага тавьж, анхааруулга өгчээ.

[Эх сурвалж: БОАЖЯ, gogo.mn](#)

ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНААС 2021 ОНЫ ДЭЛХИЙН УСНЫ ӨДРИЙГ УГТАН "УСНЫ ҮНЭЛЭМЖ" СЭДЭВТ САРЫН ЗАРЛАЛАА



Жил бүрийн 3 дугаар сарын 22-ныг дэлхийн олон улс орон цэвэр ус, ус хангамж, усны нөөцийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор Дэлхийн усны өдөр болгон тэмдэглэдэг. Анх 1993 оны 3 сарын 22-ны өдрийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Дэлхийн усны өдөр” болгон зарлан тунхагласан бол жил бүрийн энэ өдрийг НҮБ-ын Усны агегтлагаас тодорхойлсон сэдвийн хүрээнд тэмдэглэж, тухай чиглэлээр олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээн тайлбарлан таниулж байдаг. 2021 оны Дэлхийн усны өдөр “Усны үнэ цэнэ” сэдвийн хүрээнд зохион байгуулагдах юм. Энэ өдрийг угтан Хэрлэн голын сав газрын захиргаанаас "УСНЫ ҮНЭЛЭМЖ" сэдэвт нэг

сарын аян зохион байгуулж байгаагаа зарлалаа. Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор энэ удаагийн аяны хүрээнд цахим орчинд иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх, цахимаар үйл ажиллагаа зохион байгууллахаар төлөвлөсөн байна.

[Эх сурвалж: Хэрлэн голын сав газрын захиргаа](#)

УСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС ХАРИУЦАХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛД БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХАМААРАХГҮЙ

Монгол Улсын Засгийн газар цар тахлын хүнд үед иргэдийнхээ амжиргааг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд ажлын байраа хадгалахад дэмжлэг болгох зорилгоор улсын хэмжээнд бүх айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг 2021 оны долдугаар сар хүртэл чөлөөлөх шийдвэр гаргасан билээ. Тэгвэл энэ хөнгөлөлтөд Байгалийн нөөц ашигласны төлбөр буюу Ус ашигласны төлбөр хамаарахгүй тул төлбөрөө Ус сувгийн удирдах газрын www.eus.mn цахим сайтыг ашиглан цаг хугацаанд нь төлөхийг Ус сувгийн удирдлах газраас анхааруулсан байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус, эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан, эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны хэрэглээнд Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдуулна хэмээн заасан байдаг бөгөөд усаар хангагч байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашигласан усны м3 тутамд 99.12 төгрөг ногдуулан тооцож авдаг.

[Эх сурвалж: УСУГ-ын албан ёсны фэйсбүүк хуудас](#)

“ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ & ДЭД БҮТЭЦ” СЭДЭВТ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛНО



Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд олон нийтийн оролцоог хангах үүднээс мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны академи, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдад төлөвлөлтийн талаарх мэдээлэл өгөх, тэдний санал, зөвлөмжийг авах, тусгах зорилгоор үе шаттай хэлэлцүүлгүүдийг цахимаар зохион байгуулах гэж байгаа бөгөөд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр [“Улаанбаатар 2040 цахим](#)

[хэлэлцүүлэг: Инженерийн бэлтгэл арга хэмжээ & Дэд бүтэц” сэдвийн дор ус хангамж, ариутгах татуурга, инженерийн бэлтгэл арга хэмжээ](#), холбоо мэдээллийн асуудлаар цахим хэлэлцүүлэг зохион байгуулна. Хэлэлцүүлэгт оролцох хүсэлтэй хүмүүс <https://forms.gle/WD2EBMm1VYTQoeEF7> линкээр нэвтрэн мэдээллээ оруулах боломжтой. [Эх сурвалж: Хот төлөвлөлт, судалгааны институт](#)